Ж.Батсайхан

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2015-2016 ОНЫ ХАНДЛАГА

АРГА ЗҮЙН ХЯЛБАРШУУЛСАН
ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2013 он

# Өмнөх үг



Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг та бүхэнд танилцуулж байгаадаа баяртай байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд макро эдийн засгийн тэнцвэртэй, тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд эдийн засгийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, инфляцийн түвшинг 6.0 хувьд барих, дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 14.7 хувьд хүргэх, төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг нэмэгдүүлж, агаарын тээврийн салбарыг хөгжүүлэх, аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох, барилгын материалын импортыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, ногоон хөгжлийг бий болгох, хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлж, “Сум” төслийг хэрэгжүүлж эхлэх, “Ажилтай орлоготой монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлж, цалин хөлсний бодлогыг шинэчлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, эрх зүйн орчинг шинэчлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн нь 2014 онд эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, улмаар өсөлтийг бататгах боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Иргэд, олон нийтийн зүгээс Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг судлан танилцах ажлыг хөнгөвчлөх, улмаар улс орныхоо хөгжлийг төлөвлөх үйл ажиллагаанд тэдний оролцох идэвхийг дээшлүүлэхэд зохих нөлөө үзүүлэх энэхүү гарын авлагыг Иргэн танд хүргүүлж байна.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**
**Б.ГАРАМГАЙБААТАР**

# ГАРЫН АВЛАГААС ЮУ МЭДЭЖ БОЛОХ, ТҮҮНИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ТУХАЙД

Гарын авлагатай бүхэлд нь танилцсанаар улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг төлөвлөхөд хэрэглэгддэг гол гол үзүүлэлт, тэдгээрийн тодорхойлолтууд, тооцооны зарим аргачлал, 2014 онд улс орноо хөгжүүлэх талаар тавьж байгаа зорилтууд, хэрэгжүүлэх томоохон арга хэмжээний талаар товч ойлголт авах болно.

Гарын авлагын хэсэг тус бүрийн агуулгын задаргааг нарийвчлан дугаарласан (1.2.1. гэх мэт) нь сонирхсон зүйлтэйгээ хэсэгчилэн танилцах боломжийг олгоно.

Эдийн засаг, нийгмийн асуудлын гол гол үзүүлэлтүүд, тэдгээрийн нэр томъёоны тодорхойлолт, тооцооны аргачлалын талаар товч ойлголт өгөх үүднээс тусгайлан хайрцагласан “тодруулга”-ыг хийж өгөв.

**I хэсгээс** эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2015-2016 оны хандлагын талаар “зорилт-арга хэмжээ” гэсэн дарааллаар,

**II хэсгээс** УИХ-ын тогтоолууд, шаардлагатай зарим албан мэдээлэлтэй танилцах боломжтой.

Гарын авлагад тусгагдсан тоо баримт нь 2013 оны 5 дугаар сарын 24-ний 39 дүгээр тогтоол, Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл, түүний танилцуулга, хавсралт тооцоо, тоо баримтаас эх сурвалжтай болно.

Боловсруулж, хэвлэлд бэлтгэсэн
багийн гишүүд

# АГУУЛГА

**I ХЭСЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2015-2016 ОНЫ ХАНДЛАГА 5-44**

**1.1. 2014 оны үндсэн чиглэлийн агуулга, зорилтууд 6**
**1.2. Макро эдийн засгийн 2014 оны төлөв 8**
1.2.1. Эдийн засгийн бодит өсөлт 10
1.2.2. Хэрэглээний үнийн түвшин /инфляци/ 13
1.2.3. Валютын ханшны төлөв 16
1.2.4. Гадаад худалдааны төлөв 18
1.2.5. Хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн төлөв 21
1.2.6. Улсын төсвийн төлөв 24
**1.3. Бодит салбарын хөгжил 2014 онд 26**
1.3.1. Аж үйлдвэрийн хөгжил 27
1.3.2. Эрчим хүчний хөгжил 28
1.3.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжил 29
1.3.3.1. Хүнс,хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжил 29
1.3.3.2. Мал аж ахуйн салбарын хөгжил 30
1.3.3.3. Газар тариалангийн салбарын хөгжил 30
1.3.4. Зам тээвэр, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн салбарын хөгжил 31
**1.4. Хүний хөгжил 2014 онд 33**
1.4.1. Боловсрол 35
1.4.2. Соёл урлаг, шинжлэх ухаан 36
1.4.3. Хөдөлмөр эрхлэлт 37
1.4.4. Нийгмийн даатгал 38
1.4.5. Нийгмийн халамж 39
1.4.6. Эрүүл мэнд 40
**1.5. Бүс нутаг, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төлөв 2014 онд 41**
1.5.1. Бүс нутгийн хөгжил 41
1.5.2. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төлөв 42
**1.6. Гадаад бодлого, батлан хамгаалах салбар 2014 онд 43**
**1.7. Засаглал, эрх зүйн шинэчлэлийн төлөв 2014 онд 44**

**II ХЭСЭГ. АЛБАН МЭДЭЭЛЭЛ, ХАВСРАЛТУУД 45-62**
**2.1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоол 46**
**2.2. Хавсралтууд 47**



# I ХЭСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2015-2016 ОНЫ ХАНДЛАГА

# 1.1. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН АГУУЛГА, ЗОРИЛТУУД

**АГУУЛГА**

**2014**

- ✓ Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд Шинэчлэлийн Засгийн газрын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлж инфляцийг бууруулах, гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, хяналт, удирдлагын тогтолцоо, бүртгэл, мэдээллийн системийг боловсронгуй болгох, үнэт цаас, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- ✓ Үйлдвэржилтийн бодлогын хүрээнд газрын тос боловсруулах үйлдвэр, цахилгаан станц, барилгын материалын үйлдвэр, төмөр замын суурь бүтцийг шинээр барих зэрэг томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого, арга хэмжээг үргэлжлүүлнэ.
- ✓ Улсын төсөв, Хөгжлийн банк, Засгийн газрын бонд, гадаадын шууд хөрөнгө оруулалт, зээл, тусламж, төр–хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан үйлдвэрлэл, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтуудыг хэрэгжүүлнэ
- ✓ Нийгмийн суурь үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

**ЗОРИЛТ**

**2014**

- Макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангаж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлнэ.
- Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлнэ.
- Олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг нэмэгдүүлж, агаарын тээврийн салбарыг хөгжүүлнэ.
- Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож, авто тээврийн салбарын дэд бүтцийг хөгжүүлнэ.
- Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлнэ.
- Эдийн засгийн өсөлтийг хангах эрчим хүчний бодлого хэрэгжүүлнэ.
- Барилгын материалын импортыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.
- Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
- Орчны бохирдлоос хамгаалж, доройтлыг бууруулж, ногоон хөгжлийг бий болгоно.
- Биологийн олон янз байдлыг хамгаална.
- Хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.
- Ажилтай, орлоготой Монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний бодлогыг шинэчилнэ.
- Нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлнэ.
- Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн орчныг шинэчилнэ.
- Хүүхэд, сурагч, багш, оюутан нэг бүрийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, боловсролын тогтолцоог шинэчилнэ.
- Боловсролын салбарын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.
- Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.
- Эрүүл мэндийн оношлогоо, эмчилгээ, үйлчилгээг иргэн бүрт хүргэх боломжийг бүрдүүлнэ.
- Соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалан, соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.
- Биеийн тамирыг хүний өдөр тутмын хэрэглээ болгох, спортоор хичээллэгчдийн залгамж халааг бэлтгэх, биеийн тамир, спортын салбарын материаллаг баазыг бэхжүүлнэ.
- Төрийн үйлчилгээ, хүртээмжийг дээшлүүлж, хууль сахиулах болон хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлнэ.
- Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагаанд төв, орон нутаг, мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулж, эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ.
- Батлан хамгаалах чадавхийг нэмэгдүүлж, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчнийг төлөвшүүлнэ.

## 1.2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН 2014 ОНЫ ТӨЛӨВ

*2014 онд Оюутолгойн зэс–алтны ордын үйлдвэрлэл 2013 оноос бараг 2 дахин нэмэгдэж, "Эрдэнэс Тавантолгой"–н Баруун болон Зүүн цанхийн олборлолт эрчимтэй явагдаж эхлэх ба мөн газрын тос, төмрийн хүдрийн олборлолт ч эдгээр онуудад эрчимтэй нэмэгдэх хандлагатай байна. Дөрөвдүгээр цахилгаан станц болон Хөтөлийн цементийн үйлдвэрүүдийн өргөтгөлийг барьж байгуулна. Цахилгааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Тавдугаар цахилгаан станц, Тавантолгойн цахилгаан станцыг барих ажлуудыг үргэлжлүүлэн, төмөр замын суурь бүтцийг шинээр барих ажлыг хийнэ. Газар тариалангийн салбарт үр ашиг, бүтээмж, гарцыг дээшлүүлэх, бүтээгдэхүүнийг экспортлох чиглэлээр эрчимтэй ажиллана.*

*Эдгээр бодлогын үр дүнд 2014 онд эдийн засаг харьцангуй өндөр түвшинд хүрч, макро эдийн засгийн тэнцвэртэй байдал хадгалагдана.*

*Монгол Улсын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйл бол дэд бүтцийн хөгжил сул байдал бөгөөд дэд бүтцийг сайжруулах асуудал нь эдийн засгийн эрчимтэй өсөлтийг тэтгэх, хот, хөдөөгийн хөгжлийг дэмжих, орон сууцжуулахад хамгийн чухал асуудал болоод байна.*

**ЗОРИЛТ 2014**

- ✓ Макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангаж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлнэ.

## Тодруулга1

- ***ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО:***
  *Аливаа улс орны төр засгаас эдийн засгийн талаар заавал шийдвэрлэж байх дараахь зорилтуудыг эдийн засгийн бодлого гэнэ. Үүнд:*

| | |
|---|---|
| *Эдийн засгийн эрх чөлөөг хангах* | *Аж ахуйн үйл ажиллагаанд оролцож буй үйлдвэрлэгч, хэрэглэгч бүх субъектийн эрх мэдэл, өмчийн эрх чөлөөг хангах, сонголт хийх боломж олгох* |
| *Ажлаар бүрэн хангах* | *Ажлын чадвартай ажиллахыг хүсч буй бүх хүмүүс ажилтай байх бололцоог хангах замаар ажилгүйдлийн түвшинг зохистой хэмжээнд барих* |
| *Эдийн засгийн өсөлтийг хангах* | *Хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх* |
| *Үнийн тогтвортой байдлыг хангах* | *Инфляцийн эсрэг үйл ажиллагаа явуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах* |
| *Орлогыг шударга хуваарилах* | *Цөөн бүлгийн тансаг хэрэглээг улам нэмэгдүүлж, нөгөө бүлгүүдийн амьдралыг ядууралд оруулахгүй байхуйцаар орлогыг хуваарилах* |
| *Хүн амд эдийн засгийн халамж үзүүлэх* | *Хөдөлмөрийн чадваргүй, ажил хийх боломжгүй хүмүүсийн амьдралын баталгааг хангах* |
| *Гадаад худалдааны тэнцлийг хангах* | *Гадаад худалдаа, санхүүгийн гадаад харилцаанд оновчтой тэнцвэр бүрдүүлэх* |
| *Хүрээлэн буй орчныг хамгаалах* | *Эдийн засгийн хөгжил ба хүрээлэн буй орчны зохицолдоог хангах* |

## 1.2.1 ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ ӨСӨЛТ

**2014**

- **Эдийн засгийн өсөлт 14.7 хувьд хүрнэ.**
- **Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний* хэмжээ 5300.0 ам.долларт хүрнэ.**

***Эдийн засгийн өсөлт, 2014 он.***




**Эдийн засгийн өсөлт, салбараар**

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| ДНБ-ий бодит өсөлт | **12.3** | **16.0** | **14.7** | **11.8** | **14.6** |
| Хөдөө аж ахуй | 21.3 | 5.4 | 3.9 | 4.0 | 2.8 |
| Үйлдвэр | 10.1 | 36.2 | 24.8 | 12.5 | 26.2 |
| Үйлчилгээ | 13.4 | 10.8 | 11.8 | 14.2 | 11.0 |

* –урьдчилсан гүйцэтгэл
* * –төсөөлөл

тодруулга2–ыг үз

## 2014 онд
## Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлүүд

- ✓ 2013 оны дунд үеэс Оюутолгойн зэс–алтны ордын үйлдвэрлэл өрнөж, бүтээгдэхүүнээ экспортолж эхлэх бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлтөд ихээхэн хувь нэмэр үзүүлэхээр байна. Тус ордын үйлдвэрлэл 2014–2016 онд 2013 оныхоос 2–3 дахин нэмэгдэж, Тавантолгойн Баруун болон Зүүн цанхийн олборлолт эрчимтэй явагдана. Мөн газрын тос, төмрийн хүдрийн олборлолт ч нэмэгдэх хандлагатай байна.
- ✓ 2014 онд Дөрөвдүгээр цахилгаан станц болон Хөтөлийн цементийн үйлдвэрийн өргөтгөл, 2015 онд газрын тосны боловсруулах үйлдвэр ашиглалтад орох ба мөн эдгээр онуудад авто зам, төмөр замын бүтээн байгуулалтын ажлууд хийгдэнэ.
- ✓ Газар тариалангийн салбарт бүтээмж, гарцыг дээшлүүлэх, бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд экспортлох чиглэлээр эрчимтэй ажиллана



## Эдийн засгийн бодит өсөлт, 2012–2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр

- ➢ 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр эдийн засаг 12.3 хувиар өсч, ДНБ–ий хэмжээ нэрлэсэн үнээр 13,994.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- ➢ 2012 онд нэг хүнд ногдох ДНБ–ий хэмжээ 3613.3 ам.доллар болов.
- ➢ Эдийн засгийн бодит өсөлтийг 2013 онд 16.0 хувь байхаар урьдчилан төсөөлж байна.
- ➢ Нэг хүнд ногдох ДНБ–ий хэмжээ 2013 онд 4391 ам.долларт хүрэх урьдчилсан тооцоо гарч байна.

## Тодруулга 2

- **ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ** гэдэг нь дараа жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийг зохиоход Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлж, Улсын Их Хурлаас зөвшөөрсөн баримт бичиг юм.

- **ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ.** Эдийн засгийн өсөлтийг нэлээд өргөн хэрэглэгдэж байгаа дараах хоёр тодорхойлолтоор хэмждэг:

  ✓ Ашиглаж байгаа үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн тоо хэмжээг нэмэгдүүлсний буюу техник технологийг боловсронгуй болгосны үр дүнд үндэсний хийт бүтээгдэхүүн /ҮНБ/-ий хэмжээнд гарах бодит өөрчлөлтөөр
  ✓ Нэг хүн амд ногдох бодит орлогын хэмжээ нэмэгдэх буюу ҮНБ-ний бодит хэмжээ өсөх үйл явцаар

$$\text{Эдийн засгийн өсөлтийн хурдац} = \frac{\text{(тухайн оны ҮНБ)} * 100\%}{\text{суурь оны ҮНБ}}$$

- Улс орны дотооддоо тухайн жилд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүнийг **"ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН"** гэдэг бөгөөд тухайн орны үйлдвэрлэх хүчний нөөцөөр нэг жилд үйлдвэрлэж бий болгосон материал баялгийн хэмжээг зах зээлийн өртгөөр илэрхийлдэг. Нийт бүтээгдэхүүнийг хүн амд хуваавал нэг хүнд ногдох хэмжээ гарна. Үүгээр улс орны хөгжлийн болон амьдралын түвшинг тооцоолдог. Нийт бүтээгдэхүүний хэмжээ, түүний өсөлт нь улс орны хөгжлийн шийдвэрлэгч хүчин зүйл юм.

- ДНБ дээр тухайн улсын иргэдийн гадаад дахь хөрөнгө оруулалтаас олох орлогыг нэмбэл үндэсний нийт бүтээгдэхүүн /ҮНБ/ гарна.
- Үндэсний нийт бүтээгдэхүүнээс капиталын элэгдэлийн шимтгэлийг хасвал **ҮНДЭСНИЙ ЦЭВЭР БҮТЭЭГДЭХҮҮН** гарна.
- Дотоодын нийт бүтээгдэхүүнээс шимтгэлийг хасвал **ДОТООДЫН ЦЭВЭР БҮТЭЭГДЭХҮҮН** гарна.
- Үндэсний нийт бүтээгдэхүүнээс шимтгэл ба шууд биш татваруудыг хасвал цэвэр орлогуудын нийлбэр буюу **ҮНДЭСНИЙ ОРЛОГО** гарна.
- Үндэсний орлогоос пүүсүүдийн хувьцаа эзэмшигчиддээ өгөлгүй хөрөнгө оруулалт хийсэн ашиг болон татварыг хасч дээр нь тэтгэвэр, тэтгэмж зэрэг эдийн засагчдын хэллэгээр "шилжүүлэх төлбөр"-ийг нэмбэл хүмүүсийн гар дээр бэлэн очих "хэрэглээнд зарцуулах" буюу **"БЭЛЭН ОРЛОГО"** гарна.

## 1.2.2. Хэрэглээний үнийн түвшин (Инфляци)

**2014**

- **Бодит эдийн засаг, мөнгө, сангийн харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, инфляцийн зорилтот түвшин /жилийн дундаж хэмжээ/ 6.0 хувиас ихгүй байна.**




*тодруулга 3–ыг үз

## 2014 онд Инфляцид нөлөөлөх хүчин зүйлс:

- ✓ Инфляцийн түвшин дунд хугацаанд тогтворжуулах үүднээс нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна. Тухайлбал, анхан шатны мал нядалгааны цехийг мал бэлтэлийн гол, томоохон сум,суурind байгуулж, мах бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог боловсронуй болгох, хот суурин газрын иргэдэд зориулан нөөцийн мах бэлтгэнэ. Малын тоо, толгой сүүлийн 2 жилд нилээд өсөх хандлагатай байгаа нь 2014 онд малчдаас нийлүүлэх махны хэмжээ хэвийн түвшинд хүрэх бодит бололцоо бүрдэж байна.
- ✓ Суурь үнэнд хамгийн ихээр нөлөөлдөг түлш, шатахууны үнийг богино хугацаанд тогтвортой байлгахын тулд газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, өөрийн олборлосон газрын тосны тодорхой хувийг БНХАУ–д боловсруулж, дотоодын хэрэгцээнд нийлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.
- ✓ Засгийн газрын гадаад зах зээлээс босгосон хөрөнгө болон хувийн хэвшлийн хөрөнгөөр дэд бүтэц, үйлдвэрлэлийн томоохон бүтээн байгуулалтыг хийхээр төлөвлөөд байгаа нь дунд хугацаанд нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулна гэж үзэж байна.



## Хэрэглээний үнийн индекс /инфляци/, 2012–2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр

- ➢ Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляцийн түвшин 2012 оны эцсээр улсын хэмжээнд 14.0 хувьтай гарлаа.
- ➢ Засгийн газар Монголбанкны “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”–ийн хэрэгжилт 2013 оны эхний улиралд үр дүнгээ өгч, инфляцийн түвшин 9.8 хувь болж бага зэрэг буураад байна.

## Тодруулга 3

- **ҮНИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН** (Инфляци). – Энэ нь үнийн индексийн тусламжтай хэмжиж байгаа өргөн хэрэглээний бүлэг барааны буюу хэрэглээний сагс болгон тооцсон барааны үнийн дундаж түвшинг тодорхойлдог. Үнийн индекс нь тодорхой хугацааны доторх үнийн дундаж түвшингийн өөрчлөлтийг илэрхийлэх ба дараах томъёогоор тооцно.

$$\text{Тухайн жилийн үнийн индекс} = \frac{\text{Тухайн оны үнэ} * 100\%}{\text{Суурь оны үнэ}}$$

✓ Хэрэглээний сагс гэдэг бол амьдралынхаа хэвийн үйл ажиллагааг хангаж байгаа статистикийн дундаж амьжиргаатай гэр бүлийн хэрэгцээг хангахад зайлшгүй шаардагдах бараа үйлчилгээний цуглуулга юм.

✓ Манай оронд хэрэглээний үнийн индексийн сагсыг 1991 оны 9–р сараас Олон улсын Валютын сангийн аргачлалаар тооцож эхэлсэн бөгөөд 2001 оноос эхлэн хэрэглээний сагсанд 280 гаруй нэрийн бараа, үйлчилгээг багтааж хэрэглээний үнийн индексийг тооцож байна.

## 1.2.3. Валютын ханшны төлөв

**2014**

*тодруулга 4-ийг үз

- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэх, уян хатан тогтох зарчмын үргэлжлүүлэн баримтална.

### *Тодруулга 4*

- **Валютын ханшийг тодорхойлдог хүчин зүйлүүд:**

  ✓ Эдийн засгийн гол үйл явдлууд /арга хэмжээнүүд/
  ✓ Бүтээмжийн өөрчлөлт
  ✓ Мөнгө санхүүгийн талаарх төрийн бодлого
  ✓ Үнэ, зээлийн хүү
  ✓ Улс төр, сэтгэл зүйн хүчин зүйлүүд
  ✓ Хүлээлт
  ✓ Гадаад валютын эрэлт нийлүүлэлт

- **Валютын зах зээлийг зохицуулах талаар Засгийн газраас авч байгаа арга хэмжээ нь өөрийн үндэсний валютын ханшид девальваци болон ревальваци хийх чиглэлээр валютын зах зээлийг өдөөж байдаг.**

  ✓ ***Девальваци нь*** өөрийн орны валютын солилцооны ханшийг бууруулахад чиглэгдсэн Засгийн газрын үйлдлийг хэлдэг. Девальвацийн үед бусад орнууд худалдан авсан бараандаа бага валют төлөх учраас тухайн орны бараа үйлчилгээний үнэ олон улсын зах зээл дээр хямдрана. Хилийн чанадаас худалдан авсан бараа үйлчилгээний үнэ нэмэгдэж, улмаар импорт хумигдахад нөлөөлж, дотоодын эрэлт буудаг.

  ✓ ***Ревальваци нь*** өөрийн орны валютын солилцооны ханшийг өсгөхөд чиглэгдсэн Засгийн газрын үйлдлийг хэлдэг.

  ✓ ***Валютын интервенци нь*** гадаад орны валютыг худалдах, худалдан авах замаар үндэсний валютын ханшид нөлөөлөх үйлдэл.

## Тодруулга 5

- **Голланд өвчин:**

Эдийн засагт шинээр хөрөнгө оруулалт орж ирэх нь бусад салбарын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн зарим салбар уналтад орох тохиолдол байдаг байна. 1959 онд Нидерландын хойд тэнгист газрын тос илэрсний улмаас газрын тосны үйлдвэрлэл нэмэгдэж улмаар тосны экспорт өсчээ. Гэвч дотоод валютын ханш чангарсны улмаас бусад салбарын экспорт буурч, газрын тосноос бусад салбарт ажилгүйдэл нэмэгдэх байдлаар эдийн засагт сөргөөр нөлөөлсөн байна. Ханшийн чангаралтын нөлөөгөөр боловсруулах салбарын худалдаалагддаг төрлийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар буурч, үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлдөг энэхүү байдлыг голланд өвчин гэж нэрлэдэг бөгөөд газрын тосны олборлолтоос өмнө Нидерландын экспортын гол бүтээгдэхүүн байсан Алтанзул цэцгийн экспорт эрс буурч, эдийн засгийн өрөөсгөл бүтэц бий болж байжээ. Тодруулбал, эдийн засгийн нэг салбарын үйл ажиллагаа бусад салбарын үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөхийг ГОЛЛАНД ӨВЧИН гэдэг байна.

- **Баялгийн хараал:**

Ангола, Нигер, Судан, Конго зэрэг Африк тивийн ихэнхи орнууд газрын тос, очир алмаз гэх мэт үнэт эрдэнээр баялаг боловч байгалийн баялаггүй зүүн өмнөд Азийн орнууд болох Япон, Өмнөд–Солонгос, Тайвань, Сингапур зэрэг оронтой харьцуулахад амьдралын чанар доогуур, нэг хүнд ногдох орлого маш бага байна. Баялагтай боловч хөгжил буурай байгаа эдгээр орнуудыг “баялгийн хараал” тусчээ гэж дүгнэдэг. Байгалийн баялаг арвинтай орнуудын нэг хүнд ногдох орлогын өсөлт нь баялгийг ашиглаагүй үеийн нэг хүнд ногдох орлогын өсөлтөөс доогуур байх үзэгдлийг БАЯЛГИЙН ХАРААЛ гэж тодорхойлох бөгөөд улс орнууд баялгийн хараалд өртдөг олон шалтгаан байдаг байна. Тухайлбал, тухайн орны эдийн засаг цөөн тооны түүхий эд, баялгийн дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс хэт хамааралтай, эмзэг бүтэцтэй байх, Засгийн газар нөөцийг үр ашиггүй удирдах, улс төрийн тогтворгүй байдал, авлигал зэрэг нь улс орныг баялгийн хараал тусахад хүргэдэг байна.

## 1.2.4. Гадаад худалдааны төлөв

**2014**

- ✓ Гадаад худалдааны бараа эргэлт 2014 онд 16.7 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 8.4 тэрбум ам.доллар, импорт 8.3 тэрбум ам.доллар болж болохоор байна.
- ✓ Экспортын хэмжээ 2014 онд 2013 оноос 31.9 хувиар нэмэгдэж, 8.4 тэрбум ам.доллар болохоор байна.
- ✓ Импортын хэмжээ 2014 онд өмнөх оноос 14.1 хувиар өсч, 8.3 тэрбум долларт хүрэхээр байна.

**Гадаад худалдааны төсөөлөл, сая ам.доллараар, 2011–2014 оноор.**




*Урьдчилсан гүйцэтгэл
**Төсөөлөл

## Гадаад худалдаа, 2012–2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр

- Монгол Улсын гадаад худалдааны бараа эргэлт 2012 онд 15.0 тэрбум ам.долларт хүрэв.
- Монгол Улсын нийт экспорт 2012 онд 2011 оноос 8.3 хувиар буурч, 4.4 тэрбум ам.доллар болов.
- Импорт 2012 онд 3.2 хувиар нэмэгдэж, 6.7 тэрбум ам.доллар болов.

**Гадаад худалдаа, сая ам.доллараар, 2006–2012 он.**



## Тодруулга 6

- *Ямар ч улс орны хувьд гадаад худалдааны гол асуудал нь экспорт нь импортоосоо ямагт түрүүлж байх явдал юм. Энэхүү үйл явцыг улсын хэмжээнд харуулдаг нэгдсэн үзүүлэлт бол гадаад худалдааны* ***бараа эргэлт*** *юм.*

- *Гадаад худалдааны бараа эргэлт гэж экспорт дээр импортыг нэмсэн нийлбэрийг хэлдэг.*

***Гадаад худалдааны эргэлт = экспорт+импорт***

- *Экспорт, импортын нийлбэрээр гадаад худалдааны эргэлтийг тодорхойлдог бол экспорт, импортын зөрүүгээр гадаад худалдааны тэнцлийг тодорхойлдог.*

- *Хэрэв +(нэмэх) тэмдэгтэй гарвал гадаад худалдааны тэнцэл ашигтай, улс орны хөгжил дэвшил дээгүүр байгааг илэрхийлнэ.*

*Улс орны эрх ашиг, аюулгүй байдлыг хангах үүднээс улс орон бүхэн импортоосоо давсан экспорттой байх нь хамгийн гол зорилт байдаг хэдий ч эдийн засгийн чадавхи, улс орны хөгжлийн түвшингөөс хамаараад улс орон бүхэн ингэж чаддаггүй.*
*Гадаад худалдааны алдагдалыг арилгах арга зам нь үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үүний дотор олон улсын зах зээлийн шаардлага хангасан чанартай, хүний орчин үеийн хэрэглээнд илүү нийцэж тохирсон үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд анхаарах явдал юм.*

## 1.2.5. Хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн төлөв

**ЗОРИЛТ**

**2014**

- Эдийн засгийн өндөр өсөлтийг хангах санхүүгийн салбарын хөгжлийг олон улсын түвшинд ойртуулах бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2014**

✓ Үнэт цаасны зах зээлийн тухай шинэчилсэн хуулийг хэрэгжүүлж эхэлнэ.

✓ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

✓ Ипотекийн хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлыг эхэлнэ.

✓ Гадаад зах зээлээс хямд эх үүсвэрийг татаж, бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлнэ.

✓ Гадаадын зарим орнуудын экспортын болон бусад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг ашиглана.

✓ Гадаад худалдааны гол түнш орнуудтай тухайн орны валютаар арилжаа хийх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр ажиллана.

## Тодруулга 7

**ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ** бол улс орны гадаад эдийн засгийн тухайн үеийн байдлыг илэрхийлдэг чухал ойлголт юм.
Төлбөрийн тэнцэл нь тухайн жилийн хугацаанд аль нэг орны хувь хүмүүс, пүүс компани, Засгийн газрын байгууллагуудаас бусад орнуудын мөн тийм хэмжэний субъектүүдтэй хийсэн гэрээ, хэлцлүүдийн нэгтгэсэн тэнцэл бөгөөд дараахь 3 хэсгээс бүрддэг.

### *I. Урсгал дансны тооцоо (а+б+1.5.+1.6.)*

1.1.Барааны экспорт
1.2. Барааны импорт

а.Гадаад худалдааны тэнцлийн үлдэгдэл(+,-) ашигтай эсвэл алдагдалтай

1.3.Үйлчилгээний орлого
1.4.Үйлчилгээний зарлага

б. Худалдаа үйлчилгээний тэнцлийн үлдэгдэл (+,-)

1.5.Хөрөнгө оруулалтаас орох цэвэр орлого (–)
- –гадагш шилжүүлсэн ногдол ашиг
- –хамтарсан үйлдвэрийн хийсэн дахин хөрөнгө оруулалтын хэмжээ

1.6.Урсгал шилжүүлгүүд /цэвэр/ [+,–]
- –Засгийн газрын шилжүүлгүүд
- –Хувийн гүйвуулгууд

### *II. Капиталын хөдөлгөөн буюу Санхүүгийн ба хөрөнгийн дансны тооцоо*

2.1.Капиталын экспорт
- 2.1.1.Урт ба дунд хугацааны хөрөнгө оруулалт
  - –шууд хөрөнгө оруулалт
  - –санхүүгийн хөрөнгө оруулалт
  - –ашигласан зээл

2.2. Капиталын импорт
- 2.2.1.Зээлийн үндсэн өрийн төлбөр
- 2.2.2. Богино хугацааны зээл
- 2.2.3 Бусад төлбөр

Санхүүгийн ба хөрөнгийн тэнцлийн үлдэгдэл (+,-)

**Нийт төлбөрийн тэнцэл =Урсгал дансны тэнцэл (I)+санхүүгийн болон хөрөнгийн дансны тэнцэл (II)**

### *III Гадаад валютын албан нөөц*

Төлбөрийн тэнцлийн тэнцвэргүй байдлыг улс өөрийн төв банкны мэдэлд байгаа гадаад валютын албан нөөцийг ашиглах замаар даван туулж болдог.

## Тодруулга 7–ийн үргэлжлэл

- **Гадаад валютын цэвэр албан нөөцийг** гадаад актив /валютын харилцах, хадгаламж, кассын үлдэгдэл, мөнгөжсөн алт, гадаад орны Засгийн газрын үнэт цаас/, богино хугацаатай пассив /богино хугацаатай гадаад өр, гадаадын хөрөнгө/ –ын зөрүүгээр тооцдог.

| | |
|---|---|
| + | ***Гадаад актив*** (валютын харилцах+хадгаламж+кассын үлдэгдэл+мөнгөжүүлсэн алт+гадаадын Засгийн газрын үнэт цаас) |
| – | ***Богино хугацаатай пассив*** (гадаад өр+гадны хөрөнгө) |
| = | ***Гадаад валютын цэвэр албан нөөц*** |

✓ Мөнгөжсөн алт нь олборлосон алтыг хайлуулан цэвэршүүлж гадагш худалдахад бэлэн болгосныг хэлдэг бөгөөд гадаад валют гэж тооцогддог.

- **Гадаад валютын улсын цэвэр нөөцийг** арилжааны бүх банкуудын гадаад актив, богино хугацаатай гадаад пассивын зөрүүгээр тооцдог.

- **Нийт мөнгө /М2/ нь** банкнаас гадуур байгаа бэлэн мөнгө, банкинд байгаа харилцах дансдын үлдэгдэл /М1/ дээр төгрөгийн хадгаламж, гадаад валютын харилцах, хадгаламжийг нэмсэн нийлбэр юм.

## 1.2.6.Улсын төсвийн төлөв байдал

**2014**

Дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын эзлэх хэмжээг 35,0 хувь,

Дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн нийт зарлагын эзлэх хэмжээг 37,0 хувь,

Дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн алдагдалын эзлэх хэмжээг 2,0 хувь

Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт 14,7 хувь

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2014**

- ✓ Төсвийн шинэтгэлийг үргэлжлүүлж, орон нутгийн бие даах байдлыг бэхжүүлэх, төсвийн зохистой харьцааг хадгална.
- ✓ Үнэ, тарифын тухай хуулийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- ✓ Баялгийн сангийн тогтолцоог Монгол Улсад бий болгон хөгжүүлнэ;

### *Тодруулга 8*

- **УРСГАЛ ТЭНЦЭЛ** нь төсвийн урсгал орлого, урсгал зарлагын зөрүүгээр илэрхийлэгддэг бөгөөд төлөвлөсөн урсгал хэрэгцээгээ /зардлаа/ хасаад цаана нь өр зээл болон хуримтлал /хөрөнгө оруулалт/-д зориулагдан үлдэж буй хөрөнгийн хэмжээг харуулдаг үзүүлэлт бөгөөд тухайн улс орны төсвийн дотоод эх үүсвэрийн чадавхийг илтгэдэг.

- **ТӨСВИЙН НИЙТ ТЭНЦЭЛ** нь төсвийн нийт орлого, нийт зарлагын зөрүүгээр тус тус илэрхийлэгддэг бөгөөд төлөвлөсөн нийт хэрэглээг /нийт зардлыг/ хангахад дутагдаж буй хөрөнгийн хэмжээг харуулдаг үзүүлэлт бөгөөд тухайн улс орны Засгийн газарт нэмэлт дотоод, гадаад эх үүсвэр /зээл/ шаардагдаж байгааг илтгэн үзүүлдэг.

*Улсын төсвийн нийт тэнцэл зохих түвшинд алдагдалтай байх тохиолдолд энэ алдагдалыг:*

*-гадаад /цэвэр/*
*-дотоод /цэвэр/ эх үүсвэрүүдээр санхүүжүүлэн тэнцвэржүүлдэг.*

✓ *Гадаад /цэвэр/ эх үүсвэр нь төслийн болон санхүүгийн эх үүсвэр байдаг.*

✓ *Дотоодын /цэвэр/ эх үүсвэр нь өмч хувьчлалын орлого, банкны болон банкны бус байгууллагаас авах зээл байдаг.*

✓ *Цэвэр гэдэг утга нь авах өгөх хоёрын зөрүү буюу авахаас нь өгөхийг хасаад гарсан цэвэр үлдэгдэлийг хэлнэ.*

# 1.3. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖИЛ 2014 ОНД

- **Уул уурхай.** Оюутолгойн уулын баяжуулах үйлдвэр эхлэхтэй холбогдуулан бүтээгдэхүүний чанарт шинжилгээ хийх орчин үеийн лабораторийг байгуулах, Таван толгойн ордын Зүүн Цанхийн уурхайг түшиглэн нүүрс баяжуулах үйлдвэр, Цагаан суваргын ордод түшиглэн баяжуулах үйлдвэрийг барих ажлыг эхлүүлж, занарын тархацыг шинжлэн үзэж, тус бүтээдэхүүнийг ашиглах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр “Шатдаг занар” бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- **Хүнд үйлдвэр.** Ашигт малтмалыг түүхий эд хэлбэрээр гаргахыг үе шаттай бууруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, Сайншандад аж үйлдвэрийн паркийг байгуулах, Дархан–Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн орчин үеийн техник, технологи бүхий төмөрлөгийн цогцолбор байгуулах, нүүрснээс хий, шингэн түлш гаргах ажлыг эрчимжүүлэх, нүүрсний химийн үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр ажиллана
- **Эрчим хүч.** 2014 онд эрчим хүчний салбарт шинээр бий болж байгаа эргэлтийг хангахад чиглэсэн ойрын болон урт хугацааны эх үүсвэрийг бий болгох чиглэлээр ДЦС–5, Тэлмэний 60 МВт–ын ДЦС–ыг барьж байгуулах зэрэг томоохон ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
- **Хүнсний үйлдвэрлэл.** Импортын хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болох зорилтын хүрээнд газар тариалан, фермерийн бүс нутгийг түшиглэн хуурай сүү боловсруулах үйлдвэр, стандартын шаардлагад нийцсэн, хүнсний аюулгүй байдлыг хангахуйц тээвэр, агуулахын сүлжээ, логистик байгуулахыг дэмжинэ.
- **Хөнгөн үйлдвэр.** Хөнгөн үйлдвэрийн хөгжлийг дэмжих, түүхий эдийн нийлүүлэлтийг сайжруулах, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний боловсруулах үйлдвэрт ноос, арьс ширээ тушаасан малчдад урамшуулал олгох, боловсрол, эрүүл мэнд, уул уурхайн салбарт шаардлагатай оёмол бүтээгдэхүүнийг үндэсний аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

## 1.3.1. Аж үйлдвэрийн хөгжил

**ЗОРИЛТ**
**2014**

- **Ашигт малтмалыг түүхий эд хэлбэрээр гаргахыг үе шаттай бууруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.**

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**
**2014**

✓ Сайншандад аж үйлдвэрийн паркыг байгуулах, Дархан–Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн орчин үеийн техник, технологи бүхий төмөрлөгийн цогцолбор байгуулах, нүүрснээс хий, шингэн түлш гаргах ажлыг эрчимжүүлэх, нүүрсний химийн үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр ажиллана.

✓ Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн “Барилгын материалыг эх орондоо үйлдвэрлэдэг болох” зорилтын хүрээнд барилгын материалын дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлснээр 2015 онд цементийн хүчин чадал жилд 4.0 сая тонн, арматурын хүчин чадал 300.0 мянган тоннд хүргэн, дотоодын хэрэгцээг хангахын зэрэгцээ сантехникийн хуванцар материал, дулаан тусгаарлах материалын тодорхой хувийг эх орондоо үйлдвэрлэх хүчин чадалтай болно.

## 1.3.2. Эрчим хүчний хөгжил

**ЗОРИЛТ 2014**

- **Эдийн засгийн өсөлтийг хангах эрчим хүчний бодлого хэрэгжүүлнэ.**

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 2014**

- ✓ Төвлөрсөн дулаан хангамж, дулааны эх үүсвэр, дулааны сүлжээний бодлогын хэрэгжилт, зохицуулалтын асуудлыг зохион байгуулах ажлын хүрээнд “ДЦС–5”–ыг Төвлөрсөн дулаан хангамжийн системтэй холбох дулааны төв магистраль шугам барина.
- ✓ “ДЦС–4” 100МВт–аар өргөтгөхтэй холбогдуулан дулаанжуулалтын тоног төхөөрөмжийн судалгааны ажлыг хийнэ.
- ✓ Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт “УС–15”–ыг өргөтгөн 250Гкал/ц хүчин чадалтай дулаан станц барина.
- ✓ Аймгийн төвүүдэд дулааны станц барьж ард иргэдийн ая тухтай байдлыг хангана.

## 1.3.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжил

### 1.3.3.1. Хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжил

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 2014**

- ✓ Газар тариалан, фермерийн бүс нутгийг түшиглэн хуурай сүү боловсруулах үйлдвэр, стандартын шаардлагад нийцсэн, хүнсний аюулгүй байдлыг хангахуйц тээвэр, агуулахын сүлжээ, логистик байгуулахыг дэмжинэ.
- ✓ Улсын хэмжээнд нийт бэлтгэж буй ноосны дийлэнх хувийг дотоодын үйлдвэрлэлд ашиглах, ноосон даавууны үйлдвэрлэлийг эхлүүлэх, арьс ширийг боловсруулж эцсийн бэлэн бүтээгдэхүүн болгох, арьс ширний үйлдвэрүүдийг хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээлээр дэмжиж, үйлдвэрлэлийн шат дамжлагыг нэмэгдүүлэх, үйлдвэрт орчин үеийн дэвшилтэт технологи бүхий цэвэрлэх байгууламжийг барих, ноолуур бэлтгэлийн 50-иас доошгүй хувийг эцсийн бүтээгдэхүүн болгож боловсруулах чиглэлийг баримтлан ажиллана.

## 1.3.3.2. Мал аж ахуйн салбарын хөгжил

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ
2014

- ✓ Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжиж хангайн бүсийн аймгуудад өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн, говь хээрийн бүсэд өндөр ашиг шимт хонь, ямааны, томоохон хот, аймгийн төвүүдийн ойролцоо шувууны аж ахуйг хөгжүүлэх бодлого баримтлан, сүү, өндөгний хэрэгцээгээ хангах бодлого баримтална.
- ✓ 2013–2015 онд дэлхийн стандартад нийцсэн орчин үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлсэн, мал аж ахуйн бүтээгдэхүүн, генетик судалгаа, биотехнологи, малын үр хөврөлийн үйлдвэрлэлийн өндөр технологи бүхий лабораториудыг байгуулна.

## 1.3.3.3. Газар тариалангийн салбарын хөгжил

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ
2014

- ✓ Газар тариалангийн талаар баримтлах бодлого нь нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, нэр төрлийг олшруулахад чиглэгдэнэ.
- ✓ Гол нэрийн хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээг бүрэн хангадаг болох зорилгоор элит болон супер элит үрийн хангамжийг нэмэгдүүлэх, хүнсний ногооны тариалалт, хураалтыг механикжуулах, агуулахыг байгуулна.
- ✓ Инженерийн болон энгийн хийцтэй услалтын системийг сэргээн хөгжүүлнэ.

## 1.3.4. Зам тээвэр, барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн салбарын хөгжил

**ЗОРИЛТ 2014**

- Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлнэ.
- Олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг нэмэгдүүлж, агаарын тээврийн салбарыг хөгжүүлнэ.
- Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож, авто тээврийн салбарын дэд бүтцийг хөгжүүлнэ.
- Барилгын материалын импортыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.

# ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 2014

- ✓ 2014–2016 онуудад Тавантолгой–Сайншанд–Чойбалсан, Хөөт–Бичигт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, одоо байгаа төмөр замын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

- ✓ Агаарын тээврийг хөгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд Хөшгийн хөндийн олон улсын шинэ нисэх буудлыг барьж байгуулах, орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх, навигацийн орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангах, агаарын хөлгийн парк шинэчлэлтийг хийж, агаарын хөлгийн тоог нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авна.

- ✓ 2014 онд Говь–Алтай, Завхан, Сүхбаатар аймгийг, 2015 онд Ховд, Увс, Баян–Өлгий аймгийг тус тус нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбоно. Мөн транзит тээврийг нэмэгдүүлэх зорилгоор Алтанбулаг–Улаанбаатар–Замын–Үүд чиглэлийн хурдны замыг болон АН–4 чиглэлийн буюу Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг ирэх жилүүдэд барихаар төлөвлөж байна.

- ✓ Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх зорилтын хүрээнд “Гудамж” төслийг хэрэгжүүлж, хоёр түвшний гүүрэн гарцыг барьж, одоо байгаа замын сүлжээний ашиглалтын нөхцөлийг сайжруулах бодлого баримтлан ажиллана.

- ✓ Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулахад анхаарч, хот, тосгон, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлын харилцан уялдсан тогтолцоог бүрдүүлэх, нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийг тэтгэх чадвар бүхий бүс нутаг, хотжилтын нэгдмэл орчинг бий болгоход чиглсэн бодлого хэрэгжүүлэн ажиллана.

- ✓ Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөх замаар иргэд өөрсдөө инженерийн бүрэн хангамжтай орон сууц барих нөхцөлийг бүрдүүлнэ.

# 1.4. ХҮНИЙ ХӨГЖИЛ 2014 ОНД

- *Нийгмийн суурь үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахын тулд эмнэлгүүдэд оношилгооны тоног төхөөрөмжүүдийг нэмж суурилуулах, мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлж, үйл ажиллагааг хурдан шуурхай болгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.*

- *Боловсролын салбарт сургуулийн өмнөх насны хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын хэрэглэгдэхүүн, арга зүй, технологийг шинэчлэн нэвтрүүлж хөгжүүлэх, бага, дунд боловсролын салбарт хийгдэх чанарын шинэчлэлийн бодлогын хүрээнд үндэсний стандарт, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажлыг стандарт, хөтөлбөр боловсруулах, боловсролын үнэлгээ хийх, багш бэлтгэх сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэх, багшийн мэргэжил дээшлүүлэх, сурах бичиг, сургалтын орчинг сайжруулах, сургалтын байгууллагын чадавхийг бэхжүүлэх гэсэн асуудлын хүрээнд хийж хэрэгжүүлнэ. .*

- *Монгол Улс эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, гэр бүлийг бэхжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэнээр хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.*

- *Өсвөр үе залуучуудын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн үйлчилгээ үзүүлэх, амьдрах ухаан, хөдөлмөрлөх зан үйлийг төлөвшүүлэх хөгжлийн төвүүдийг бий болгох, үйлчилгээний стандартыг тогтоох, Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын төвийг бүх аймаг, дүүрэгт байгуулах асуудлыг судална.*

- *Хөдөлмөрийн багтаамж ихтэй салбаруудыг бодлогоор дэмжих талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс үйлдвэрлэлийн салбарт хөдөлмөр эрхлэлтийн өсөлтийг бий болгох төсөл, хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн оролцоотой хэрэгжүүлнэ.*

## Тодруулга 9

### Хүний хөгжлийн индекс /ХХИ/

- Хүний хөгжлийн индексийг иргэдийнх нь дундаж наслалт, боловсрол (насанд хүрсэн хүн амын бичиг үсэгт тайлагдсан байдал, бүх нийтийн боловсролд хамрагдсан байдал), бодит орлого (нэг хүнд оногдох ДНБ-ий хэмжээ, худалдан авах чадвараар хэмжигдэх амьдралын түвшин) гэсэн үндсэн гурван хэмжүүрийг ашиглан тооцож байна. Эдгээр хэмжүүрүүд нь тус бүртээ өөрийн индекстэй бөгөөд тухайн улсын дундаж наслалт нь 85, нэг хүнд ногдох ДНБ жилд 40 мянган ам.доллар, насанд хүрсэн бүх хүн уншиж, бичиж чаддаг, хүүхэд багачууд нь бүх шатны сургуульд 100 хувь хамрагддаг бол “1” гэсэн оноо авах юм. Хүний хөгжлийн индексийг гаргаснаар хувь хүний амьдралын түвшинг дээшлүүлж, нийгмийн бүх салбарт хөгжиж, боловсрох боломжийг бий болгох арга хэмжээ авахад ашигладаг байна.

  - ✓ **Боловсролын индексийг** насанд хүргэгчдийн бичиг үсэгт тайлагдсан байдал, бага дунд дээд боловсролд хамрагдсанаар тэгээс нэг хүртэлх оноогоор хэмжиж байгаа бөгөөд 0.9-өөс дээш оноо авах нь боловсролтой, хөгжилтэй улсыг илэрхийлдэг байна. Хүн амын боловролын түвшний индексээр хамгийн өндөр нь Австрали Улс (0.993), Норвеги Улс (0.989) тэргүүлж байна. Монгол Улс (0.913) өндөр үзүүлэлттэй улсын тоонд багтаж байна.

  - ✓ **Дундаж наслалт** өндөр хөгжилтэй орнууд эдийн засгийн хувьд хүчирхэг бөгөөд иргэд нь өрсөлдөх чадвар хамгийн өндөр байдгийг үздэг байна. Дэлхийд дундаж наслалтаар хамгийн өндөр үзүүлэлттэй нь Япон Улс 0.973 (82.7 жил) байна. Монгол Улс 0.687 гэсэн үзүүлэлттэй байна.

  - ✓ **Дотоодын нийт бүтээгдэхүүнийг** Дэлхийн банкны системээр эдийн засгийн бүх орлогыг тооцох болон хэрэглээ, үйлчилгээ, экспорт зэргээр бүх зардлаар нь тооцдог байна. Дэлхийн банкны тооцоогоор нэг иргэнд 11.9 мянган ам.доллараас дээш мөнгөн дүн ногдож байвал өндөр орлоготой, 3.8 мянгаас 11.9 мянган ам.доллар бол дундаас дээгүүр орлоготой, 976-аас 3.8 мянган ам.доллар бол дунд зэргийн, 975 ам доллараас доош орлоготой бол буурай оронд тооцогддог байна. Энэ үзүүлэлтээр АНУ тэргүүлж, хамгийн өндөр нь байгаа бөгөөд Япон удаалсан байна. Монгол Улсын ДНБ-ий индекс 0.580 гэсэн үзүүлэлттэй байна.

## 1.4.1. Боловсрол

**ЗОРИЛТ**
**2014**

- Хүүхэд, сурагч, багш, оюутан нэг бүрийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, боловсролын тогтолцоог шинэчилнэ.
- Боловсролын салбарын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**
**2014**

- ✓ Шинэчлэлийн Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан "Эрдэм боловсролтой Монгол хүн" хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.
- ✓ Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын төвшинд хүүхэд бүрийг хөгжүүлэх стандарт, хөтөлбөр боловсруулах, боловсролын үнэлгээ, багш бэлтгэх сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, багшийн мэргэжил дээшлүүлэх, сурах бичиг, сургалтын орчин, байгууллагын чадавхи, менежментийг бэхжүүлэх гэсэн өөр хоорондоо уялдаа холбоо бүхий 6 багц асуудлын хүрээнд олон улсын жишигт нийцсэн боловсруулалт хийж, арга зүй, технологийн шинэчлэл хийнэ.
- ✓ Хүүхэд бүрийн бүтээлч, амьдрах чадварыг хөгжүүлэх "Авьяас", "Ном", "Багшийн хөгжил", Сургалтын орчин, лаборатори–хэрэглэгдэхүүний хүртээмжийг сайжруулах хөтөлбөрүүдийг тус тус хэрэгжүүлнэ. Цэцэрлэг, бага ангийн багшийн ачааллыг үнэлэмжтэй уялдуулах арга хэмжээ авна. Боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний системийг байгуулна.
- ✓ Дээд боловсролын хөгжлийг дэмжих эрх зүйн орчинг сайжруулж, судалгаа сургалт хосолсон тогтолцоог дэмжинэ. Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ. Германы инженерийн сургалтын технологийг нэвтрүүлж, багш, инженер бэлтгэх чиглэлийн сургуулиудын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулахад дэмжлэг үзүүлнэ. Сургалтын төрийн сангийн санхүүжилт, Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, хөтөлбөрийн хүрээнд дэлхийн шилдэг сургуулиудад оюутан сургах тогтолцоог хөгжүүлнэ.
- ✓ Насан туршийн боловсролын аймаг, дүүргийн төв, сумын нэгжийн байр, материаллаг бааз, сургалтын орчин нөхцөлийг бэхжүүлж, боловсролын хөтөлбөр, сургалтын агуулгын хүрээг боловсруулна.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт оношилгоо, үнэлгээний журам боловсруулна. Багшлах боловсон хүчин бэлтгэх, олон улсад мэргэшүүлэх, давтан сургах ажлыг хэрэгжүүлж, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг боловсруулан, багшийн арга зүй технологийг хэрэгжүүлнэ. Хүүхдийг нөхөн сэргээх зориулалтын тоног төхөөрөмж бүхий орчинг бүрдүүлнэ.

## 1.4.2.Соёл урлаг, шинжлэх ухаан

**ЗОРИЛТ 2014**

- Шинжлэх ухаан технологийн үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.
- Соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалан, соёлын үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлнэ.
- Биеийн тамирыг хүний өдөр тутмын хэрэглээ болгох, спортоор хичээллэгчдийн залгамж халааг бэлтгэх, биеийн тамир, спортын салбарын материаллаг баазыг бэхжүүлнэ.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 2014**

✓ 2014 онд Соёл, урлагийн салбарын эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлж Үндэсний соёлын уламжлалт мэдлэг, илэрхийллийн тухай, музейн тухай хуулийн төслүүдийг боловсруулж соёлын өвийг хадгалж хамгаалах ажлыг шинэ түвшинд хүргэх, хүн амын, ялангуяа хөдөөгийн иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллана.

✓ Биеийн тамир, спортын салбар нь нийгмийн бүлгүүдийн идэвхтэй оролцоо, сонирхолд тулгуурласан хот, улсын эдийн засгийн хөгжлийг хурдасгах хөшүүрэг байх хэмжээнд хүргэнэ. Нэг хүнд ногдох биеийн тамир, спортын барилга байгууламж, заал талбайн хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ үзүүлэх үйлчилгээ, хэрэглэл материал, тоног төхөөрөмжийн чанарыг сайжруулна

✓ Шинжлэх ухаан, технологийн салбарын удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн менежментийг боловсронгуй болгоно. Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх бодлоготой уялдуулан шинжлэх ухааны паркийг байгуулах ажлын бэлтгэлийг хангана. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, хөгжлийн хандлагатай уялдуулан шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг хэрэгжүүлнэ.

## 1.4.3. Хөдөлмөр эрхлэлт

**ЗОРИЛТ 2014**

- **Ажилтай орлоготой монгол хүн" хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний бодлогыг шинэчилнэ.**

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 2014**

- ✓ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүчний хөгжлийн бодлогыг эдийн засгийн салбар, бүс, орон нутгаар тодорхойлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй оновчтой зохицуулах, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрүүдэд үндэсний ажиллагчдыг түлхүү ажиллуулж, нийгмийн хамгааллыг нь баталгаажуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ажлын байрыг дэмжих хөдөлмөр эрхлэлтийн идэвхитэй бодлогын оновчтой хувилбарыг бий болгох зэрэг бодлого хэрэгжүүлнэ.
- ✓ Хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний бодлогыг салбарын түвшний тарифын хэлэлцээр байгуулах, ажилчдын хөдөлмөрийн хөлсний тарифын сүлжээг нэвтрүүлэх механизм бүрдүүлнэ.
- ✓ Хөдөлмөрийн багтаамж ихтэй салбаруудыг бодлогоор дэмжих үүднээс үйлдвэрлэлийн салбарт хөдөлмөр эрхлэлтийн өсөлтийг бий болгох төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

## 1.4.4. Нийгмийн даатгал

**ЗОРИЛТ**
**2014**

- **Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн орчныг шинэчилнэ.**

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**
**2014**

- ✓ Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчлэх, тэтгэврийн тогтолцоог олон давхаргат даатгалын тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- ✓ Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулна.
- ✓ Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагчдад зориулсан тэтгэврийн даатгалын тусгай сан, хөтөлбөрийг бий болгоно.
- ✓ Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтрийг цахим үнэмлэхээр солих арга хэмжээг зохион байгуулна

## 1.4.5.Нийгмийн халамж

**ЗОРИЛТ**
**2014**

- **Нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлнэ.**

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**
**2014**

✓ Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өнчин хүүхэд зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн бодлогыг дэмжиж, нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг хувийн хэвшил, ТББ–аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.

✓ Эх /эцэг/ нь төрүүлсэн хүүхдээ хоёр нас хүртэл, ихэр хүүхдийг гурван нас хүртэл өөрөө асран хүмүүжүүлэх тэтгэмж, дэмжлэгийн эрх зүйн орчныг бий болгох

## 1.4.6. Эрүүл мэнд

**ЗОРИЛТ**
**2014**

- **Эрүүл мэндийн оношлогоо, эмчилгээ, үйлчилгээг иргэн бүрт хүргэх боломжийг бүрдүүлнэ.**

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**
**2014**

- ✓ Шинэчлэлийн Засгийн газрын 2012–2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийг “Шударга өрсөлдөөн, чөлөөт сонголтод суурилсан, олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийн оношлогоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг иргэн бүрт олгох” зорилттойгоор хэрэгжүүлэн ажиллана.
- ✓ Уг хөтөлбөрийн хүрээнд 2014–2016 онуудад шаардлагатай бүх аймгуудад “Оношлогооны төв” байгуулах, гадаад эмчилгээний урсгалыг бууруулах зорилгоор “Оношлогоо эмчилгээний төв” байгуулах, хүүхдэд тохиолдож буй төрөлхийн гаж хөгжил, удамшлын эмгэгийг эрт оношлох боломжийг бий болгох эрүүл мэндийн салбарын шинэчлэлд нийцүүлэн хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

# 1.5.БҮС НУТАГ, БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ТӨЛӨВ 2014 ОНД

## 1.5.1.Бүс нутгийн хөгжил

**ЗОРИЛТ 2014**

- **Хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлж, иргэдийн аятай амьдрах орчныг бүрдүүлнэ.**

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 2014**

✓ Аймгийн төвүүдийг хөгжүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

✓ "Сум" төслийг хэрэгжүүлж эхэлнэ.

## 1.5.2. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төлөв

**ЗОРИЛТ 2014**

- **Орчны бохирдлоос хамгаалж, доройтлыг бууруулж, ногоон хөгжлийг бий болгоно.**
- **Биологийн олон янз байдлыг хамгаална.**
- **Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.**

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 2014**

- ✓ Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохгүй газар нутгийн хил хязгаарыг тогтоох, өв газруудын хил хязгаарыг тогтоох судалгаа хийнэ. Эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийнэ.
- ✓ Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, байгаль орчны тэнцвэрт байдлыг ханган, эдийн засаг, нийгмийн эмзэг байдал, эрсдлийг үе шаттайгаар бууруулах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- ✓ Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр нийслэл дэх нам даралтын уурын зуухыг шинэчлэх, гэрийн зуухны үр ашиг, түлшний хангамжийг дээшлүүлэх, Эрдэнэт, Дархан хотод агаарын бохирдлыг тасралтгүй хэмжих хяналтын автомат станцыг байгуулах ажлыг эхэлнэ. Барилгын норм дүрэм, стандарт, хот байгуулалтад эрчим хүч, ус, дулаан хэмнэх, бохирдол, хаягдлыг багасгах шинэ техник, технологийг нэвтрүүлэх боломжийг судална.
- ✓ Хог хаягдлын үндэсний хөтөлбөрийг шинэчлэн, хог хаягдлыг бууруулах багасгах, тусгай зориулалтын хог цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг нэвтрүүлнэ. Газрын доорх болон гадаргын усны орчим, хаягдал ус зайлуулах цэгт хяналт–шинжилгээний горимын ажиглалт хийх, сүлжээ байгуулах чиглэлээр ажиллана.
- ✓ Биологийн олон янз байдлыг хамгаалахад онцгой ач холбогдолтой болон гол мөрний урсац бүрэлдэх усны эх газрыг улсын тусгай хамгаалалтад хамруулах судалгааг хийж, 1,5 сая га талбай бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авна. Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Ховор ан амьтан, өвс ургамлын төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төсөл хэрэгжүүлнэ.
- ✓ Монгол Улсыг нэгдсэн бодлоготойгоор гадаадад сурталчлан, салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлж, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадвар өндөртэй, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилт тавин ажиллана.
- ✓ Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор зах зээлийн эрэлтэд нийцсэн парк, музей, цогцолбор, тухайлбал, төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор үлэг гүрвэлийн цогцолбор музей, палеонтологийн лаборатори, аяллын төвүүдийг байгуулан тухайн нутгийн үзмэр, бизнес, брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах түшиц болгон ашиглана.

# 1.6. ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР 2014 ОНД

## ЗОРИЛТ 2014

- **Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулж, эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ.**
- **Батлан хамгаалах чадавхийг нэмэгдүүлж, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчнийг төлөвшүүлнэ.**

## ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 2014

✓ Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг тууштай үргэлжлүүлэн хэрэгжүүлж, улмаар НҮБ–ын бүх гишүүн улстай дипломат харилцаа тогтоох, хөрш хоёр улс болон “гуравдагч хөрш” орнууд, хөгжиж буй орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Ази, Номхон далайн бүс нутгийн интеграцид оролцоогоо идэвхжүүлнэ.

✓ Батлан хамгаалах салбар 2014 оны үйл ажиллагаандаа “Батлан хамгаалах чадавхийг нэмэгдүүлж, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг төлөвшүүлэн, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах” чиглэлийг дэвшүүлж ажиллана

# 1.7.ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТӨЛӨВ 2014 ОНД

**ЗОРИЛТ 2014**

- **Төрийн үйлчилгээ, хүртээмжийг дээшлүүлж, хууль сахиулах болон хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлнэ.**
- **Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагаанд төв, орон нутаг, мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.**

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 2014**

- ✓ Хууль эрх зүйн бодлогын шинэчлэлийн хүрээнд төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцооны шинэтгэл, эрүүгийн бодлогын шинэтгэл, хорих байгууллагын тогтолцооны шинэчлэл, хилийн шалган нэвтрүүлэх тогтолцооны шинэчлэл, хуулийн боловсролын шинэчлэлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд Маршалын алба, Мөрдөх албыг шинээр зохион байгуулах, цагдаагийн байгууллагыг шинэчлэн зохион байгуулах, хууль сахиулах байгууллагуудыг цахим мэдээллийн сүлжээнд холбох ажлууд хэрэгжинэ.
- ✓ “Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэлийн бодлого”-ыг 2007-2021 онд хэрэгжүүлэх стратегийн 5 зорилтын хүрээнд төрийн албан тушаалын бүх зэрэглэлийн албан тушаалтанд тавигдах шаардлага, стандарт, эзэмшсэн байвал зохих мэдлэг, ур чадварын матрикс боловсруулж хэрэгжүүлэх, төрийн албаны чиг үүрэг болон үйлчилгээг зохистой арга механизмаар үзүүлэхэд шаардагдах төрийн албаны зохистой хэмжээг тодорхойлох, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын болон зарим сонгосон салбарын нийтлэг болон туслах чиг үүргийг хамруулан стратегийн чиг үүргийн шинжилгээ хийх арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

# II ХЭСЭГ

# АЛБАН МЭДЭЭЛЭЛ, ХАВСРАЛТУУД

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

*2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр        Дугаар 39        Улаанбаатар хот*

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй нягт уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг оны эхнээс жигд хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцыг бүтэн жилээр гаргаж Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** З.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 39 дүгээр
тогтоолын хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| Д/д | Урт ба дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг | Зорилт, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2014 онд хүрэх түвшин, үр дүн | Хөрөнгийн эх үүсвэр / тэрбум төгрөг/ | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ.МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | |
| Зорилт 1.Макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангаж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлнэ. | | | | | | |
| 1.1 | “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” /цаашид “ҮХЦБ” гэх/ | Эдийн засгийн өндөр өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэх | Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид “ДНБ” гэх/-ий бодит өсөлт, хувиар | 14.7 | - | Эдийн засгийн хөгжлийн яам /цаашид “ЭЗХЯ” гэх/ |
| | | | Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, ам.доллароор | 5,300.0 | - | ЭЗХЯ |
| 1.2 | “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” / цаашид “ЗГҮАХХАХТ” гэх/-ний 2.1-2.3, 21, 22 дахь заалт | Эдийн засгийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, инфляцийг бууруулах<br><br>Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Жилийн эцсийн инфляцийн зорилтот түвшин, хувиар | 6 | - | ЭЗХЯ, Уул уурхайн яам / цаашид “УУЯ” гэх/, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам /цаашид “ҮХААЯ” гэх/, Зам, тээврийн яам /цаашид “ЗТЯ” гэх/, Барилга, хот байгуулалтын яам /цаашид “БХБЯ” гэх/, Монголбанк |
| 1.3 | ЗГҮАХХАХТ-ний 35.5 дахь заалт | Гадаад зах зээлээс хямд эх үүсвэрийг татаж, бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ЭЗХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.4 | | Баялгийн сангийн тогтолцоог Монгол Улсад бий болгон хөгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | Сангийн яам /цаашид “СЯ” гэх/ |
| 1.5 | | Нийгмийн даатгалын санг мөнгөжүүлэх замаар ипотекийн хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлыг эхлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ЭЗХЯ, БХБЯ, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам /цаашид “ХАХНХЯ” гэх/ |
| 1.6 | ЗГҮАХХАХТ-ний 35.7 дахь заалт | Гадаадын зарим орны экспортын болон бусад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг ашиглах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ЭЗХЯ, Гадаад харилцааны яам /цаашид “ГХЯ” гэх/, УУЯ |
| 1.7 | ЗГҮАХХАХТ-ний 5.10 дахь заалт | Гадаад худалдааны гол түнш улсуудтай тухайн улсын валютаар арилжаа хийх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ЭЗХЯ |
| 1.8 | ЗГҮАХХАХТ-ний 24.4 дэх заалт | Төсвийн шинэтгэлийг үргэлжлүүлж, орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, төсвийн зохистой харьцааг хадгалах | ДНБ-д нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын эзлэх хувиар | 35 | - | СЯ |
| | | | ДНБ-д нэгдсэн төсвийн зарлагын эзлэх хувиар | 37 | | |
| | | | ДНБ-д нэгдсэн төсвийн нийт алдагдлын эзлэх хувиар | 2 | | |
| 1.9 | ЗГҮАХХАХТ-ний 22.2 дахь заалт | Үнэ, тарифын тухай хуулийг шинээр боловсруулж, хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ЭЗХЯ |
| 1.10 | ЗГҮАХХАХТ-ний 35.1, 35.4 дэх заалт | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | Санхүүгийн зохицуулах хороо |
| 1.11 | ЗГҮАХХАХТ-ний 10 дахь заалт | Банк, санхүү, бирж, мэдээллийн технологи, амралт цэнгээний болон агаарын замын зангилаа төв байгуулах чиглэлээр ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ЭЗХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **ХОЁР.БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилт 2.Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлнэ.** | | | | | | |
| 2.1 | “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого” /цаашид “ТТЗТББ” гэх/-ын 3.2.2 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 107.1 дэх заалт | Төмөр замын суурь бүтцийг барих бодлогыг хэрэгжүүлэх | Суурь бүтэц барих чиглэл | 3 | - | ЗТЯ |
| 2.2 | “Транзит Монгол” Үндэсний хөтөлбөрийн 5.2.5 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 119.1 дэх заалт | Холимог тээврийн ачааны нэгдсэн терминал, логистикийн төв байгуулах бодлого хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 206.6 Гадаад эх үүсвэр | ЗТЯ |
| **Зорилт 3.Олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг нэмэгдүүлж, агаарын тээврийн салбарыг хөгжүүлнэ.** | | | | | | |
| 3.1 | ҮХЦБ-ын 5.3.1.5 дахь заалт, “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”, ЗГҮАХХАХТ-ний 84.1 дэх заалт | Олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг нэмэгдүүлэх | Шинээр нэмэгдэх олон улсын нислэгийн давтамж | 2 | - | ЗТЯ |
| | | | Шинээр нэмэгдэх олон улсын нислэгийн чиглэл | 1 | - | |
| **Зорилт 4.Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож, авто тээврийн салбарын дэд бүтцийг хөгжүүлнэ.** | | | | | | |
| 4.1 | ҮХЦБ-ын 5.3.1.2 дахь заалт, “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн 4.4.2.10 дахь заалт | Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлэх | Аймгийн төвийг нийслэл хоттой холбох хатуу хучилттай зам, км | 775.4 | - | ЗТЯ |
| 4.2 | ЗГҮАХХАХТ-ний 109.1, 109.2 дахь заалт | “Гудамж” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 50 хүртэл | - | ЭЗХЯ, ЗТЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.3 | “Транзит Монгол” Үндэсний хөтөлбөрийн 2.25 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 220.3 дахь заалт | Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах | Тусгай замын автобусны дэд бүтцийн барилгын ажлын явц, хувиар | 10 хүртэл | 18.0 Улсын төсөв 90.0 Гадаад эх үүсвэр | ЗТЯ |
| 4.4 | | ОХУ, БНХАУ-ыг холбосон төмөр зам, авто зам, нефть, байгалийн хий, эрчим хүчний дэд бүтцийн урсгалыг бий болгох бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах | Бодлого тодорхойлох ажлын явц, хувиар | 100 | - | ЭЗХЯ, ЗТЯ, Эрчим хүчний яам /цаашид “ЭХЯ” гэх/, УУЯ |
| **Зорилт 5.Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлнэ.** | | | | | | |
| 5.1 | ҮХЦБ 5.2.1.1 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 39.1 дэх заалт | Геологийн албыг бэхжүүлж, геологийн судалгааг өргөжүүлэх | Эрдэс баялгийн мэдээллийн сангийн бүрдэлт, хувиар | 30 | - | УУЯ |
| 5.2 | ЗГҮАХХАХТ-ний 55 дахь заалт | Эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | УУЯ |
| 5.3 | ЗГҮАХХАХТ-ний 40 дэх заалт | Газрын тосны тухай, Ашигт малтмалын тухай хуулиудыг шинэчлэн боловсруулах, Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн тухай, Уул уурхайн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиуд болон Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогыг шинээр боловсруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | УУЯ |
| 5.4 | ЗГҮАХХАХТ-ний 43.1 дэх заалт | Стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийж, нөөцийг тогтоосон зарим ордыг стратегийн ач холбогдол бүхий ордод хамруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | - | УУЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5.5 | ЗГҮАХХАХТ-ний 103.1 дэх заалт | Шатдаг занарын эрэл хайгуулыг идэвхжүүлж, шатдаг занараас шатахуун гаргах үйлдвэр, туршилтын ажлыг эхлүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | УУЯ |
| 5.6 | ЗГҮАХХАХТ-ний 40.13 дахь заалт | Эзэнгүй, эвдрэлтэй талбайг нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх | Нөхөн сэргээлтэд хамрагдах талбайн хэмжээ, хувиар | 10 | - | УУЯ |
| 5.7 | ЗГҮАХХАХТ-ний 99.1 дэх заалт | Газрын тос боловсруулах дотоодын үйлдвэрийг барьж эхлэх | Барилгын ажлын явц, хувиар | 30 | - | УУЯ |
| 5.8 | ЗГҮАХХАХТ-ний 100.2 дахь заалт | Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор улсын шатахууны нөөц хадгалах агуулахыг байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | УУЯ |
| 5.9 | ЗГҮАХХАХТ-ний 103.1 дэх заалт | Хийн түлшний үйлдвэрлэлийг хөгжүүлж, холбогдох норм, стандартыг шинэчлэн боловсруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | УУЯ |
| **Зорилт 6.Эдийн засгийн өсөлтийг хангах эрчим хүчний бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 6.1 | ЗГҮАХХАХТ-ний 66.1, 67.2, 67.3, 67.5 дахь заалт | Эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх | Шинээр барих дулааны цахилгаан станцын тоо | 4 | 220.0 Гадаад эх үүсвэр | ЭХЯ |
| | | | Өргөтгөх цахилгаан станцын тоо | 2 | - | |
| 6.2 | ЗГҮАХХАХТ-ний 66.4 дэх заалт | Гэр хорооллын цахилгаан хангамжийг найдвартай болгох | Байршлын тоо | 113 | 7.8 Улсын төсөв | ЭХЯ |
| **Зорилт 7. Барилгын материалын импортыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.** | | | | | | |
| 7.1 | ЗГҮАХХАХТ-ний 5.7 дахь заалт | Барилгын материалын импортыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх | Дотор ханын хавтан, ламинатан шал, хуванцар хоолойн үйлдвэр байгуулах ажлын явц, хувиар | 30 | - | БХБЯ, ЭЗХЯ, ҮХААЯ, Хөдөлмөрийн яам /цаашид "ХЯ" гэх/ |
| 7.2 | ЗГҮАХХАХТ-ний 128.2 дахь заалт | Барилгын төлөвлөлтийн норм, дүрэм, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөн боловсруулах | Шинээр боловсруулж батлуулах барилгын стандарт | 4 | - | БХБЯ, ХЗЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7.3 | ЗГҮАХХАХТ-ний 3.7 дахь заалт | Иргэдийг түрээсийн орон сууцаар хангах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Шинээр ашиглалтад оруулах түрээсийн орон сууцны хүчин чадал | 600 айл | 30.0 Улсын төсөв | БХБЯ, СЯ |
| | | | | 396 айл | 9.5 Улсын төсөв | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| **Зорилт 8.Үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.** | | | | | | |
| 8.1 | ЗГҮАХХАХТ-ний 56.9 дэх заалт | "Сайншанд" аж үйлдвэрийн цогцолборын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Сонголт хийх үйлдвэрийн тоо | 2-оос доошгүй | - | ҮХААЯ, ЭЗХЯ |
| 8.2 | ҮХЦБ-ын 5.2.1.2.1 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 30.1 дэх заалт | Арьс шир, ноос, ноолуур, оёмол, сүлжмэл, мах сүүний чиглэлийн боловсруулах аж үйлдвэрийн салбарыг бодлогоор дэмжин хөгжүүлэх | ДНБ-д эзлэх боловсруулах аж үйлдвэрийн салбарын хувь | 9 хүртэл | - | ҮХААЯ |
| 8.3 | ҮХЦБ-ын 5.2.1.4.2 дахь заалт | Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих | Үйлдвэрлэх техникийн тоо | 250 | 2.0 Улсын төсөв | ҮХААЯ |
| | | | Механикжуулах төмс, хүнсний ногооны талбайн хэмжээ, га | 1000 | | |
| 8.4 | ЗГҮАХХАХТ-ний 93.5 дахь заалт | Био бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх | Байгуулах бордооны үйлдвэр | 1 | 4.0 Хувийн хэвшил | ҮХААЯ |
| | | | Эрдэс бордооны үйлдвэрлэлийн хүчин чадал, мян.тонн | 35.0 | | |
| 8.5 | ЗГҮАХХАХТ-ний 93.11, 97.1, 97.3 дахь заалт | Үр тариа болон жимс, жимсгэний ургацыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх | Шинээр барьж, сэргээн засварлах усалтын системийн хүчин чадлын хэмжээ услах талбай, мян.га | 3 | 30.0 Улсын төсөв | ҮХААЯ |
| | | | Алим, гүзээлзгэнэ, чавга, интоор тариалах талбайн хэмжээ, мян.га | 6 | 6.6 Улсын төсөв | |
| | | | Ургацын хэмжээ, мян.тонн | 5 | | |
| **Зорилт 9.Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 9.1 | ЗГҮАХХАХТ-ний 82 дахь заалт | Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх “Аялал жуулчлал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | Соёл спорт аялал жуулчлалын яам /цаашид “ССАЖЯ” гэх/ |
| 9.2 | ЗГҮАХХАХТ-ний 82 дахь заалт | Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ССАЖЯ |
| **ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧИН, БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилт 10. Орчны бохирдлоос хамгаалж, доройтлыг бууруулж, ногоон хөгжлийг бий болгоно.** | | | | | | |
| 10.1 | ЗГҮАХХАХТ-ний 218.1 дэх заалт | Иргэн, аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагыг дэмжиж, ногоон эдийн засгийн хөгжлийн орчныг бүрдүүлэх чиглэлээр татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Боловсруулах хуулийн төсөл | 1 | - | Байгаль орчин ногоон хөгжлийн яам /цаашид “БОНХЯ” гэх/ |
| 10.2 | ЗГҮАХХАХТ-ний 227.2, 232.1 дэх заалт | Үндэсний байгаль, соёл, түүхийн өв газруудын хил хязгаарыг тогтоох | Нийт нутаг дэвсгэрт эзлэх талбай, хувиар | 3 | - | БОНХЯ |
| 10.3 | “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн 4.4.5 дахь заалт | Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах | Цэцэрлэгжүүлэх талбай, га | 1.6 | 6.8 Улсын төсөв | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| | | | Арчилгаа, хамгаалалт хийх талбай, га | 0.65 | | |
| | | | Ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөлд хамрагдах өрхийн тоо | 10.000 | | |
| 10.4 | ЗГҮАХХАХТ-ний 257.3 дахь заалт | Европын холбооны болон олон улсын (ISO) шинэ дэвшилтэт стандарт, норм нормативыг нэвтрүүлэх | Стандарт, аргачлалын тоо | 5 стандарт, 1 аргачлал | 0.5 Улсын төсөв | БОНХЯ |
| 10.5 | ЗГҮАХХАХТ-ний 238.5 дахь заалт | “Саарал” усыг эргүүлэн ашиглахтай холбогдсон норм, стандартыг батлуулах | Норм, стандартын тоо | 1 | - | БХБЯ, БОНХЯ |
| **Зорилт 11.Биологийн олон янз байдлыг хамгаална.** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11.1 | ЗГҮАХХАХТ-ний 232.1-232.4 дэх заалт | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх | Өргөтгөх хэмжээ, сая.га | 1.5 | 0.5 Улсын төсөв | БОНХЯ |
| 11.2 | ЗГҮАХХАХТ –ний 234.9 дэх заалт, "Нэн ховор амьтныг хамгаалах" хөтөлбөр | Уур амьсгалын өөрчлөлтөд өртөх нэн ховор, ховордсон амьтдын эрсдэлийн үнэлгээ хийх, сэргээн нутагшуулах, үржүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Эрсдэлийн үнэлгээ | 1 | 1.8 Улсын төсөв | БОНХЯ |
| | | | Гаршуулан үржүүлэх төрөл зүйлийн тоо | 3 | | |
| 11.3 | ЗГҮАХХАХТ-ний 234.2 дахь заалт | Устах аюулд орж байгаа ургамлыг хамгаалах, уугуул нутагт нь сэргээх, нэн ховор, ховор ургамлыг тарималжуулах, генофондыг бий болгох | Нөхөн сэргээх талбай бүхий газрын тоо | 3 | 0.6 Улсын төсөв | БОНХЯ |
| **Зорилт 12.Хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 12.1 | ЗГҮАХХАХТ-ний 127.2 дахь заалт | Аймгийн төвүүдийг хөгжүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг шинэчлэх аймгийн тоо | 10 | 20.0 Улсын төсөв | БХБЯ, ЭЗХЯ, СЯ, ЭХЯ |
| 12.2 | ЗГҮАХХАХТ-ний 141.1 дэх заалт | "Сум" төслийг хэрэгжүүлж эхлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 30 хүртэл | - | ЭЗХЯ |
| **ДӨРӨВ.НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилт 13 ."Ажилтай, орлоготой Монгол хүн" хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний бодлогыг шинэчилнэ.** | | | | | | |
| 13.1 | ЗГҮАХХАХТ-ний 145.2 дахь заалт | Түр ажилтныг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг, урамшуулал олгох | Дэмжлэг, урамшуулалд хамрагдах аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл дэх ажлын байрын тоо | 1250 | 2.5 Улсын төсөв | ХЯ |
| 13.2 | ҮХЦБ-ын 4.8 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 146.3 дахь заалт | Хот, суурингаас хөдөө орон нутагт шилжин суурьших, ажил эрхлэх санаачилгыг зээл, санхүүгийн дэмжлэг, урамшууллын бодлогоор дэмжих | Зээл, санхүүгийн дэмжлэг, урамшуулалд хамрагдах хүний тоо | 2000 | 10.0 Улсын төсөв | ХЯ, ЭЗХЯ |
| 13.3 | | Цалин хөлсний бодлогыг шинэчлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх | Боловсруулах хуулийн төсөл | 1 | - | ХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 14 .Нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 14.1 | ЗГҮАХХАХТ-ний 149.1 дэх заалт | Эх /эцэг/ нь төрүүлсэн хүүхдээ хоёр нас хүртэл, ихэр хүүхдийг гурван нас хүртэл өөрөө асран хүмүүжүүлэх тэтгэмж, дэмжлэгийн эрх зүйн орчныг бий болгох | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ХАХНХЯ, СЯ |
| **Зорилт 15.Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн орчныг шинэчилнэ.** | | | | | | |
| 15.1 | ЗГҮАХХАХТ-ний 150.1, 35.2, 35.3 дахь заалт | Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн орчныг шинэчлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ХАХНХЯ |
| 15.2 | ЗГҮАХХАХТ-ний 150.3 дахь заалт | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагчдад зориулсан тэтгэврийн даатгалын тусгай сан, хөтөлбөрийг бий болгох | Малчдын хамрагдалтын хувиар | 35-50 | 12.6 Улсын төсөв | ХАХНХЯ |
| **Зорилт 16.Хүүхэд, сурагч, багш, оюутан нэг бүрийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, боловсролын тогтолцоог шинэчилнэ.** | | | | | | |
| 16.1 | ЗГҮАХХАХТ-ний 194 дэх заалт | Боловсролын байгууллагын олон улсын солилцооны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх | Хөтөлбөрт хамрагдах багшийн тоо | 40 | 0.8 Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам /цаашид “БШУЯ” гэх/ |
| 16.2 | ЗГҮАХХАХТ-ний 187.3, 187.4 дэх заалт | Олон улсын жишигт нийцсэн үндэсний хөтөлбөрийг боловсруулж, арга зүй, технологийн шинэчлэл хийх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 9.5 Улсын төсөв | БШУЯ |
| 16.3 | | Цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшийн ажлын ачааллыг багасгах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулж, хэрэгжүүлэх | Ээлжийн болон туслах багшийн тоо | 2500 | - | БШУЯ |
| 16.4 | | Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүй технологийг багшид эзэмшүүлэх “Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Олон улсын солилцоо үндэсний сургалтад хамрагдах багшийн тоо | 12.000 | 4.0 Улсын төсөв | БШУЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 16.5 | ЗГҮАХХАХТ-ний 201.1 дэх заалт | Инженерийн боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлж, олон улсын загварыг турших | Загвар турших сургуулийн тоо | 1 | 0.5 Улсын төсөв | БШУЯ |
| 16.6 | ЗГҮАХХАХТ-ний 201.2 дахь заалт | Багш, инженерийн чиглэлийн мэргэжлээр амжилттай суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх | Хөнгөлөлт үзүүлэх оюутны тоо | 4200 | 2.5 Улсын төсөв | БШУЯ |
| 16.7 | ЗГҮАХХАХТ-ний 204.1, 204.2 дахь заалт | “Өрсөлдөх чадвартай Монгол хүн” хөтөлбөр хэрэгжүүлэх, дэлхийн шилдэг сургуулиудад оюутан сургах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх | Дэлхийн шилдэг сургуульд суралцах оюутны тоо | 75 | 2.6 Улсын төсөв | БШУЯ |
| **Зорилт 17.Боловсролын салбарын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.** | | | | | | |
| 17.1 | | Хүүхэд бүрийг авьяаст нь тулгуурлан хөгжүүлэх “Авьяас” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Секц, дугуйлан хичээллэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдах сургуулийн тоо | 250 | 3.2 Улсын төсөв | БШУЯ |
| 17.2 | ЗГҮАХХАХТ-ний 187.7, 192.3 дахь заалт | Хүүхэд бүрд ном уншуулах эрмэлзэл төрүүлэх, унших арга зүйг түгээн дэлгэрүүлэх “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Шинээр бүтээх хүүхдийн номын тоо | 12 | 7.6 Улсын төсөв | БШУЯ |
| | | | Ангийн номын сан байгуулах сургууль, цэцэрлэгийн бүлгийн тоо | 2500 | | |
| | | | Цахим сургалтын үндэсний төвийн тоо | 2 | | |
| 17.3 | ЗГҮАХХАХТ-ний 205.1-205.6 дахь заалт | Тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг тогтолцооны хэв шинжид оруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, үнэлгээг сайжруулж, багшлах боловсон хүчнийг бэлтгэн мэргэшүүлж, давтан сургаж, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг боловсронгуй болгох | Шинээр боловсруулах журам | 1 | 5.0 Улсын төсөв | БШУЯ |
| | | | Хэвлэгдэх сурах бичгийн тоо | 2 | | |
| | | | Байгуулах танхимын тоо | 3 | | |
| | | | Мэргэжлийн ажилтны тоо | 90 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 17.4 | ЗГҮАХХАХТ-ний 187.9, 187.12, 187.13 дахь заалт | Насан туршийн боловсролын тогтолцоог бэхжүүлж, олон нийтийн хандлага, төлөвшлийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 6.0 Улсын төсөв | БШУЯ |
| 17.5 | ЗГҮАХХАХТ-ний 199.1 дэх заалт | Техник, технологийн чиглэлээр Монгол-Германы хамтарсан дээд сургууль байгуулах ажлыг эхлүүлэх | Элсүүлэх оюутны тоо | 100 | 5.0 Улсын төсөв | БШУЯ |
| 17.6 | ЗГҮАХХАХТ-ний 200.1 дэх заалт | Их сургуулиудын хотхон байгуулах чиглэлээр ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилт | - | - | БШУЯ |
| 17.7 | ЗГҮАХХАХТ-ний 193.1 дэх заалт | Боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний системийг хөгжүүлэх | Мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэлт, хувиар | 100 | 1.0 Улсын төсөв | БШУЯ |
| **Зорилт 18.Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.** | | | | | | |
| 18.1 | Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл баримтлалын 3.1.4.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 14 дүгээр зарлиг | Монгол судлалын сан байгуулж үйл ажиллагааг нь төрөөс тусгайлан дэмжих | Хэрэгжүүлэх судалгааны төслийн тоо | 20 | 2.7 Улсын төсөв | БШУЯ |
| | | | Бэлтгэх судлаачдын тоо | 40 | | |
| **Зорилт 19.Эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээг иргэн бүрд хүргэх боломжийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 19.1 | ЗГҮАХХАХТ-ний 174.1 дэх заалт | Эрүүл мэндийн салбарын ажилтны хариуцлагын даатгалын тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | Эрүүл мэндийн яам /цаашид “ЭМЯ” гэх/ |
| 19.2 | ЗГҮАХХАХТ-ний 170.2 дахь заалт | Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг өргөжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 18.5 Улсын төсөв | ЭМЯ, ХАХНХЯ |
| 19.3 | ЗГҮАХХАХТ-ний 165.1 дэх заалт | Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх | Боловсруулах стандартын тоо | 20 | - | ЭМЯ |
| 19.4 | ЗГҮАХХАХТ-ний 177.1 дэх заалт | Эмнэлгийн яаралтай тусламжийн хүрээг өргөтгөх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 50 | 18.0 Улсын төсөв | ЭМЯ |
| 19.5 | Нийгмийн халамжийн тухай хуулийн 21.1.2 дахь заалт, 21.3 дахь хэсэг | Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо | 97.000 | 2.0 Улсын төсөв | ЭМЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 19.6 | ЗГҮАХХАХТ-ний 183.1 дэх заалт | Уламжлалт эмийн түүхий эдийн стандартыг боловсронгуй болгох | Нэмэлт, өөрчлөлт оруулах стандартын тоо | 20 | - | ЭМЯ |
| 19.7 | ЗГҮАХХАХТ-ний 167.5 дахь заалт | Эмийн чанарыг баталгаажуулах стандартыг боловсруулах | Шинэчлэн боловсруулах стандартын тоо | 20 | - | ЭМЯ |
| 19.8 | ЗГҮАХХАХТ-ний 167.5, 167.6 дахь заалт | Эмийн аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлж, импортын болон дотоодын үйлдвэрлэгчдийн эмийн худалдаанд хяналт тавих | Эмийн аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх ажлын явц, хувиар | 15 | 5.0 Улсын төсөв | ЭМЯ |
| 19.9 | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6.1-6.3 дахь заалт | Эм ханган нийлүүлэх тогтолцоог бэхжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 20 | 1.5 Улсын төсөв | ЭМЯ |
| 19.10 | ҮХЦБ-ын 4.5 дахь заалт | “Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 0.4 Улсын төсөв | ЭМЯ |
| **Зорилт 20.Соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалан, соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.** | | | | | | |
| 20.1 | Соёлын тухай хуулийн 13.1.4 дэх заалт | Хөдөө орон нутгийн соёлын төвүүдийг  хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих | Соёл, урлагийн байгууллагын тоо | 230 | 2.6 Улсын төсөв | ССАЖЯ |
| 20.2 | | Соёлын биет болон биет бус өвийг хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ССАЖЯ |
| **Зорилт 21.Биеийн тамирыг хүний өдөр тутмын хэрэглээ болгох, спортоор хичээллэгчдийн залгамж халааг бэлтгэх, биеийн тамир, спортын салбарын материаллаг баазыг бэхжүүлнэ.** | | | | | | |
| 21.1 | Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр / цаашид “БТСХЦХ” гэх/-ийн 3.4.5 дахь заалт | Багийн спортыг хөгжүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх; | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ССАЖЯ |
| 21.2 | БТСХЦХ-ийн 3.1.16 дахь заалт | Аймаг, нийслэл, сум, дүүрэгт явган аялах чиглэл тогтоож, явган аяллыг хөгжүүлэх; | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 2.8 Улсын төсөв | ССАЖЯ |
| 21.3 | БТСХЦХ-ийн 3.4.5 дахь заалт | Хүн амыг чийрэгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх | Хамрагдах аймаг, дүүрэг | 21 аймаг, 9 дүүрэг | 15.0 Улсын төсөв | ССАЖЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **ТАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ** | | | | | | |
| **Зорилт 22.Төрийн үйлчилгээ, хүртээмжийг дээшлүүлж, хууль сахиулах болон хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлнэ.** | | | | | | |
| 22.1 | ҮХЦБ-ын 7.2 дахь заалт | Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, цахим мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх | Монгол Улсын иргэний үнэмлэхийг цахим хэлбэрээр төрийн үйлчилгээнд хэрэглэх хувь | 100 | 20.0 Улсын төсөв | Хууль зүйн яам /цаашид "ХЗЯ" гэх/ |
| 22.2 | ЗГҮАХХАХТ-ний 313 дахь заалт | Эрүүгийн бодлогын шинэтгэлийг хэрэгжүүлэх | Мөрдөх алба, Маршалын албыг шинээр зохион байгуулах ажлын явц, хувь | 100 | - | ХЗЯ |
| | | | Цагдаагийн байгууллагыг шинэчлэн зохион байгуулах ажлын явц, хувь | 100 | - | |
| 22.3 | ҮХЦБ-ын 4.4.2 дахь заалт, Хөгжлийн стратеги хөтөлбөр | Хорих байгууллагын тогтолцоог шинэчлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 70 | - | ХЗЯ |
| 22.4 | Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын 1.5 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 247.3 дахь заалт | "Улсын хил хамгаалалтын техник хангамжийг сайжруулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт | - | - | ХЗЯ |
| 22.5 | Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хөгжлийн стратеги, хөтөлбөрийн 4.5 дахь заалт | Хилийн шалган нэвтрүүлэх тогтолцоог шинэчлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | | ХЗЯ |
| 22.6 | | Хуулийн боловсролын шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 30 | - | ХЗЯ |
| 22.7 | ЗГҮАХХАХТ-ний 306.1 дэх заалт | Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын цахим мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх | Хууль зүйн яамны харьяа байгууллага байгуулах ажлын явц, хувиар | 100 | 2.0 Улсын төсөв | ХЗЯ |
| | | | Хууль сахиулах байгууллагуудыг цахим мэдээллийн сүлжээнд холбох ажлын явц, хувиар | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 22.8 | ҮХЦБ-ын 5.1.5.3 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 78.9 дэх заалт | Хилийн боомт дахь хяналт шалгалтыг эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүнд чиглүүлж, аюулгүйн үзүүлэлтэд суурилсан хяналт, шинжилгээг өргөжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| **Зорилт 23.Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагаанд төв, орон нутаг, мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 23.1 | ЗГҮАХХАХТ-ний 267.1 дэх заалт | Эрдэнэт, Дархан, Хархорин, Ховд, Улиастай, Зуунмод болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх | Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ | 7 | 5.0 Улсын төсөв | БХБЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Төрийн бус байгууллага |
| 23.2 | ЗГҮАХХАХТ-ний 267.2 дахь заалт | Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийх | Инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн судалгааны ажил | 1 | 2.5 Улсын төсөв | БХБЯ, БШУЯ, СЯ, Онцгой байдлын ерөнхий газар |
| **ЗУРГАА.ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ** | | | | | | |
| **Зорилт 24.Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулж, эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ.** | | | | | | |
| 24.1 | ЗГҮАХХАХТ-ний 253.2 дахь заалт | Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2011-2015 онд хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ЭЗХЯ |
| 24.2 | ЗГҮАХХАХТ-ний 253.7 дахь заалт | Япон Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллах | Байгуулж дуусгах хэлэлцээр, хэлэлцээний тоо | 5 ба 6 дугаар шатны хэлэлцээ | 0.3 Улсын төсөв | ЭЗХЯ |
| 24.3 | ҮХЦБ-ын 7.5.1.2, 7.5.2.3 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 253.4 дэх заалт | Монголын бараа, бүтээгдэхүүнийг дамжин өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлэх | Дамжин өнгөрөх тээврийн гурван талт хэлэлцээрийн бэлтгэл ажлын явц, хувиар | 100 | 0.5 Улсын төсөв | ГХЯ, Холбогдох яамд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 24.4 | ЗГҮАХХАХТ-ний 253.5 дахь заалт | АНУ-тай стратегийн түншлэл, Канад Улстай иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоох чиглэлээр ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 1.3 Улсын төсөв | ГХЯ |
| 24.5 | ҮХЦБ-ын 7.5.2.3 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 254.5 дахь заалт | Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвийг үүсгэн байгуулах олон улсын хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгож, үйл ажиллагааг эхлүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ГХЯ |
| 24.6 | ҮХЦБ-ын 7.5.1.1 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 253.12 дахь заалт | Манай улстай дипломат харилцаагүй, НҮБ-ын гишүүн улстай дипломат харилцаа тогтоох ажлыг идэвхтэй үргэлжлүүлэх | Дипломат харилцаа тогтоох улсын тоо | 5-аас доошгүй | - | ГХЯ |
| 24.7 | ҮХЦБ-ын 7.5.3.1 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 258 дахь заалт | Хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж, хилийн чанад дахь монгол иргэдийн бүртгэлийн тогтолцоог сайжруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | - | ГХЯ |
| | | | Шинээр нээх дипломат төлөөлөгчийн газрын тоо | 4-өөс доошгүй | 2.5 Улсын төсөв | |
| **Зорилт 25.Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлж, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчнийг төлөвшүүлнэ.** | | | | | | |
| 25.1 | ЗГҮАХХАХТ-ний 244.3, 244.6, 246.3 дахь заалт | Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх чиглэлээр төслүүдийг хэрэгжүүлэх | Хэрэгжүүлэх төслийн тоо | 22 | 44.0 Улсын төсөв | Батлан хамгаалах яам / цаашид "БХЯ" гэх/ |
| 25.2 | ЗГҮАХХАХТ-ний 251.3, 251.4 дэх заалт | "Мэргэжлийн анги, байгууллагыг бүсчлэн байгуулах" төслийн хүрээнд улсын хэмжээний бүтээн байгуулалтын ажилд оролцох ангиудыг бүсчлэн байгуулж эхлэх; | Ажлын явц, хувиар | 50 | 6.0 Улсын төсөв | БХЯ |
| | | | Сургалт-үйлдвэрлэлийн төвийн барилгын ажлын явц, хувиар | 30 | 3.0 Улсын төсөв | БХЯ |

---oOo---

# Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

| | 2009 | 2010 | 2011 | 2012* | 2013** | 2014** | 2015** | 2016** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Бодлогын үзүүлэлтүүд** | | | | | | | | |
| ДНБ-ий бодит өсөлт /хувь/ | -1.3 | 6.4 | 17.5 | 12.3 | 16.0 | 14.7 | 11.8 | 14.6 |
| *Хөдөө аж ахуй* | 3.6 | -16.6 | 0.3 | 21.3 | 5.4 | 3.9 | 4.0 | 2.8 |
| *Үйлдвэр* | -0.4 | 4.3 | 10.1 | 10.1 | 36.2 | 24.8 | 12.5 | 26.2 |
| *Үйлчилгээ* | 0.8 | 9.8 | 17.1 | 13.4 | 10.8 | 11.8 | 14.2 | 11.0 |
| *Уул уурхайн салбарын бодит өсөлт* | 5.8 | 3.6 | 8.7 | 8.9 | 49.0 | 31.7 | 13.2 | 32.1 |
| *Уул уурхайн бус салбарын бодит өсөлт* | -2.7 | 7.0 | 19.1 | 12.9 | 9.8 | 10.4 | 11.3 | 9.2 |
| Нэг хүнд ногдох ДНБ /мян. төгрөгөөр/ | 2432.3 | 3050.6 | 3949.3 | 4910.4 | 5,939.8 | 7,018.2 | 8,445.1 | 10,067.8 |
| Нэг хүнд ногдох ДНБ /ам.доллар/ | 1688.2 | 2264.4 | 3120.8 | 3613.3 | 4,391.7 | 5,348.8 | 6,602.9 | 8,042.0 |
| Хэрэглээний үнийн өөрчлөлт, оны эцэст | 4.2 | 13.0 | 10.2 | 14.0 | 8 | 6.0 | 6.0 | 6.0 |
| Нийт тэнцвэржүүлсэн орлогын дүн | 1993.0 | 3122.5 | 4159.6 | 4880.9 | 7088.3 | 7270.0 | 8210.6 | 9456.9 |
| Үүнээс: Урсгал орлого | 1965.5 | 3078.3 | 4141.3 | 4,840.8 | 7,087.5 | 7,269.2 | 8,209.8 | 9,456.1 |
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 2321.6 | 3080.7 | 4792.0 | 6,043.9 | 7,444.6 | 7,686.3 | 8,721.8 | 10,079.8 |
| Үүнээс: Урсгал зарлага | 1792.1 | 2256.3 | 3234.4 | 4,590.1 | 4,906.1 | 5,356.7 | 5,880.0 | 6,799.6 |
| Урсгал тэнцэл | 173.4 | 822.0 | 906.9 | 250.6 | 2181.4 | 1912.5 | 2329.8 | 2656.5 |
| Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл | -328.6 | 41.8 | -632.4 | -1163.0 | -356.3 | -416.3 | -511.2 | -622.9 |
| Тогтворжилтийн сангийн орлого | - | - | 241.0 | 87.4 | 169.8 | 244.7 | 167.9 | 212.0 |
| **Төсөв, ДНБ-д эзлэх хувь** | | | | | | | | |
| *Нийт тэнцвэржүүлсэн орлогын дүн* | 32.9 | 37.1 | 37.5 | 35.0 | 41.2 | 35.0 | 32.1 | 30.4 |
| *Урсгал орлого* | 32.5 | 36.6 | 37.4 | 34.7 | 41.2 | 35.0 | 32.1 | 30.4 |
| *Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн* | 38.3 | 36.6 | 43.2 | 43.3 | 43.2 | 37.0 | 34.1 | 32.4 |
| *Үүнээс: Урсгал зарлага* | 29.6 | 26.8 | 29.2 | 32.9 | 28.5 | 25.8 | 23.0 | 21.8 |
| *Урсгал тэнцэл* | 2.9 | 9.8 | 8.2 | 1.8 | 12.7 | 9.2 | 9.1 | 8.5 |
| *Нийт тэнцэл* | -5.4 | 0.5 | -5.7 | (8.3) | (2.1) | (2.0) | (2.0) | (2.0) |
| *Тогтворжилтийн сангийн орлого* | - | - | 2.2 | 0.6 | 1.0 | 1.2 | 0.7 | 0.7 |
| Гадаад худалдааны тэнцэл /сая ам.долл/ | (252.3) | (291.6) | (1,746.5) | (2,354.3) | (964.8) | 32.6 | 1,326.4 | 1,549.0 |
| ДНБ-д эзлэх хувь | -5.5 | -4.7 | -19.9 | -22.9 | -7.6 | 0.2 | 6.6 | 6.2 |
| Экспорт | 1902.5 | 2908.5 | 4780.4 | 4,384.6 | 6,356.4 | 8,385.1 | 11,242.4 | 11,644.8 |
| өсөлт, хувь | -25.6 | 52.9 | 64.4 | -8.3 | 45.0 | 31.9 | 34.1 | 3.6 |
| Импорт | 2131.3 | 3200.1 | 6526.9 | 6,738.9 | 7,321.2 | 8,352.5 | 9,916.0 | 10,095.8 |
| өсөлт, хувь | -34.1 | 50.1 | 104.0 | 3.2 | 8.6 | 14.1 | 18.7 | 1.8 |
| **Суурь үзүүлэлтүүд** | | | | | | | | |
| ДНБ оны үнээр, /тэрбум.төг/ | 6590.6 | 8414.5 | 11,087.7 | 13,944.2 | 17,219.5 | 20,782.7 | 25,559.6 | 31,144.0 |
| ДНБ 2005 оны зэрэгцүүлэх үнээр, /тэрбум.төг/ | 3913.7 | 4162.8 | 4891.3 | 5,492.7 | 6,370.0 | 7,305.4 | 8,163.9 | 9,351.8 |
| Хүн амын дундаж тоо, мянган хүнээр | 2709.7 | 2758.3 | 2807.5 | 2,839.7 | 2,899.0 | 2,961.3 | 3,026.6 | 3,093.4 |
| ДНБ сая ам.доллараар | 4574.4 | 6245.8 | 8761.5 | 10260.7 | 12731.6 | 15839.3 | 19984.1 | 24877.4 |

*- Урьдчилсан гүйцэтгэл

**- төсөөлөл

**© Энэхүү гарын авлагыг үнэгүй тараан байгаа бөгөөд ашиг олох зорилгоор олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.**

*Боловсруулсан:* *Ж.Батсайхан*

*Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:* *Д.Мягмарцэрэн*

*Д.Цэцэгмаа*

*ЭЗБХ–ны ажлын алба*
*Утас: 267451*
*Факс: 327016*